



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2026 оны 01 сарын 30 өдөр

Дугаар 13

Улаанбаатар хот

Сонгон шалгаруулалтад шалгарсанд тооцож,
тусгай зөвшөөрөл олгох тухай

Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 5.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 2.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Радио долгионы тухай хуулийн 5¹ дүгээр зүйлийн 5¹.1.8 дахь заалт, 11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсэг, Зохицуулах хорооны даргын 2025 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн А/294 дүгээр тушаалаар байгуулагдсан сонгон шалгаруулалтын үнэлгээний ажлын хэсгийн дүгнэлтийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Эх элгэн нутаг ХХК-ийг “Дорноговь аймгийн Замын-Үүд сумын нутаг дэвсгэрт радио өргөн нэвтрүүлгийн станцад радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрөл олгох багц бүхий сонгон шалгаруулалт”-д шалгарсанд тооцсугай.
2. Эх элгэн нутаг ХХК-д Дорноговь аймгийн Замын-Үүд сумын нутаг дэвсгэрт радио өргөн нэвтрүүлгийн станцад **89.1МГц**-ийн радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрлийг 2026 оны 01 дүгээр сарын 30-ны өдрөөс 2031 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр хүртэл 5 жилийн хугацаатайгаар олгосугай.
3. Тусгай зөвшөөрөл олгох тухай шийдвэрийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор гэрээ байгуулах үүрэгтэй болохыг дурдсугай.
4. Тусгай зөвшөөрөл олгосон этгээдтэй тусгай зөвшөөрлийн гэрээ байгуулах, энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Г.ЧИНЗОРИГ

ГИШҮҮН:

9028020169
9059214-А СБТ 74372

Б.АНХБААТАР

Б.БАТЗОРИГ

Ч.ЗОЛБАЯР

А.ЛУВСАН-ОЧИР

С.ТАМИР

А.ҮЙЛСТӨГӨЛДӨГ